



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/153

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 4.1, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 9,12 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжсэн боловсролын салбарын 26 төсөл арга хэмжээний барилга угсралтын ажлын явц, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, шинээр хэрэгжих ариун цэврийн байгууламжийг оновчтой төлөвлөх ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн болох Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын авто машины шатахууны зардалд 1,398,600 (Нэг сая гурван зуун ерэн найман мянга зургаан зуун) төгрөг, Боловсрол, шинжлэх ухааны газрын авто машины шатахууны зардалд 1,500,000 (Нэг сая таван зуун мянган) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх зардлын нийт 2,898,600 (Хоёр сая найман зуун ерэн найман мянга зургаан зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН